

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

### СЭТГҮҮЛ ЗҮЙН ОНОЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

Н.Ариунзаяа\*

\*АНУ-ын Лос-Анжелес хотын Олонулсынхэлнийсургуулийндадлагажигч, сэтгүүлзүйндоктор (Ph.D)

**Түлхүүр үг:** сэтгүүл зүйн онол, сэтгүүл зүйн онолын тулгуур ойлголт, сэтгүүлч мэргэжил, мэргэжлийн шалгуур, шинжлэх ухаан, философи, мэдээллийн технологи

**Х**үн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад нийгмийн амьдралын хүрээ тэлэхийн зэрэгцээ мэдлэг хийгээд үйл ажиллагааны шинэ шинэ төрлүүд салбарлан гарсаар байх нь зүй тогтолт үзэгдэл юм. Байгалийн шинжлэл, мэдээллийн технологийн салбарт гарч байгаа мэдлэгийн шинэ төрлүүдтэй харьцуулахад сэтгүүл зүй бол харьцангуй уламжлалт шинжтэй үйл ажиллагааны төрөл юм. Сэтгүүл зүй нийгэм, улс төрийн үйл ажиллагааны төрөл болох эх суурь тавигдсанаас хойш даруй 400 гаруй жил болжээ. Энэ хугацаанд сэтгүүл зүйн үйл ажиллагааны олон хэлбэр буюу хэрэгслүүд үүсэн бүрэлдэж, тэдгээр нь мэдээлэл дамжуулах цогц систем болтлоо тэлж, шинжлэх ухааны, тэр тусмаа мэдээллийн технологийн ололыг өргөн ашиглах болжээ. Өөрөөр хэлбэл сэтгүүл зүй нийгэм-улс төрийн үйл ажиллагааны нөлөө бүхий төрөл болж чадсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Гэтэл сэтгүүл зүйн үйл ажиллагаа тусгайлан боловсруулсан цогц онолыг

удирдлага болгож байна уу, эсвэл энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн дадлага туршлага, авьяас мэдрэмжид илүүтэй тулгуурлаж байна уу? гэдэг асуулт гарч ирнэ. Орчин үед сэтгүүл зүй шинжлэх ухаан мөн үү, түүнд хөдөлбөргүй тогтоосон хууль, категори, онолын нэгдсэн ойлголт байна уу? гэсэн асуудалд судлаачид анхаарлаа хандуулах болжээ. Тэдний зарим нь сэтгүүл зүй бол шинжлэх ухаан биш, үйл ажиллагааны төрөл гэж эрсхэн хэлж байхад, нөгөө хэсэг нь сэтгүүл зүй шинжлэх ухаан болох боломжтой, тэр чиглэл рүү ойртож байгаа гэж үздэг. Гурав дахь хэсэг нь сэтгүүл зүй шинжлэх ухаан мөн, гагцхүү онолын нэгдсэн ойлголттой болох ёстой гэсэн бодолтой байдаг. Эдгээрээс үзэхэд сэтгүүл зүй практик үйл ажиллагааны хувьд төлөвшсөн хэдий ч, онолын хувьд бүрэн цэгцэрч чадаагүй байгаа нь харагддаг. Үүнийг сэтгүүл зүй өндөр хөгжсөн орнуудын эрдэмтэн судлаачдын дүгнэлтээр лавшруулж болох юм. Оросын эрдэмтэн И.Д.Фомичева “Бид хичнээн ер бусын юм мөрөөдөж, философийн өндөрлөгт хүрэхээр тэмүүлсэн ч сэтгүүл зүй бол дунд түвшний гэж нэрлэгддэг мэдлэгийн салбар юм. Бидэнд хамгийн түрүүнд чанарын тухай ярихаас илүү шинжлэх

ухааны бүтцэд сэтгүүл зүйн эзлэх байр суурийг харгалзан үзэх ёстой”<sup>1</sup> гээд орчин үед сэтгүүл зүй хүний үйл ажиллагааны төрөл болохын хувьд төлөвших шатандаа явж байгаа бөгөөд хөгжлийн явцад харьцангуй өндөр түвшинд хүрч, шаардлагатай шинэ онолуудыг боловсруулах боломжтой гэж үзсэн байна. Түүний үзэж буйгаар сэтгүүл зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд тулгамдаж байгаа хамгийн чухал асуудал нь онолынхоо тулгуур ойлголтын аппаратыг тодорхой болгох ёстой юм байна. Тийм тулгуур ойлголтууд нь “Сэтгүүл зүй”, “ОНМХ”, “Олон нийтийн харилцаа”, “Масс-медиа” гэсэн дөрвөн ойлголт аж. Эдгээрийг онолын хувьд ягштал тодорхойлж, тэр нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн цагт сэтгүүл зүй шинжлэх ухаан болох тийш дөхөх болно гэж И.Д.Фомичева үзэж байна.

Үнэхээр ч өнгөрсөн хугацаанд дээр дурьдсан тулгуур ойлголтуудын талаар мэргэжлийн хүрээнийхэн нэгдсэн ойлголтод хүрч чадалгүй явсаар өнөөдрийг хүрсэн нь тодорхой юм. Жишээ нь зарим судлаач “Сэтгүүл зүй”, “ОНМХ” хоёрыг нэг ойлголт гэж үзэж байхад, нөгөө хэсэг нь “Сэтгүүл зүй” бол “ОНМХ”-ээс хавьгүй өргөн ойлголт гэж нотолдог. Түүнчлэн “ОНМХ” бол сэтгүүл зүйн онолын тулгуур ойлголтын нэг гэж үздэг хэсэг судлаач байхад, өөр нэг хэсэг нь түүнийг зүгээр л мэдээллийн сувгуудын нэгдэл гэж үздэг. Энэ нь сэтгүүл зүй судлаачид онолын цөм болсон ойлголт

дээрээ ч нэгдэж чадаагүйг харуулдаг. Үүнээс гадна судалгааны объект, судлагдахуун, аргын талаар ч нэгдмэл ойлголтод хүрч чадаагүй байна. Тухайлбал, сэтгүүл зүйн онолын судалгааны төвд ямар объект байх ёстой вэ гэдгийг тодруулах шаардлагатай юм. Онолын үндсэн ойлголтуудыг бусад прадигмуудтай харьцуулан эргэж харах шаардлага ч байна.

Энэ асуудлаар Оросын сэтгүүл зүйн нэрт эрдэмтэн Е.П.Прохоров тэмдэглэхдээ “Сэтгүүл зүйн шинжлэх

ухааны цаашдын хөгжил нь юуны өмнө түүний онолын үндсийг хэрхэн боловсронгуй болгох, зүй тогтлуудыг нь аль хэр няхуур нямбай судлахаас шалтгаална. Бас сэтгүүл зүйн түүх, арга зүй, ОНМХ-ийн онцлогийг судлах, сэтгүүл зүйн аль ч салбарт хуримтлагдсан мэдлэгийг

системчлэх, тэдгээрийг нэгтгэж байгаа дотоод уялдаа холбоог зөв тогтоож чадах эсэхээс шалтгаалах болно. Энэ зорилтын төвд сэтгүүл зүйн онолын категорын системийг боловсруулах, өөрөөр хэлбэл сэтгүүл зүйн мөн чанарыг ойлгоход тусалдаг үндсэн ойлголтуудын системийг боловсруулах явдал байх болно”<sup>2</sup> гэжээ.

Сэтгүүл зүй онолын хувьд шинжлэх ухаан болж чадсан эсэхийг шалгахын тулд мэргэжил судлаач эрдэмтдийн боловсруулсан аливаа үйл ажиллагаа нь мэргэжил, эсвэл шинжлэх ухаан мөн, бишийг тодруулах шалгуур дээр тавьж үзэх хэрэгтэй юм. Тийм шалгуур



*Сэтгүүл зүй онолын хувьд  
шинжлэх ухаан болж чадсан  
эсэхийг шалгахын тулд мэргэжил  
судлаач эрдэмтдийн боловсруулсан  
аливаа үйл ажиллагаа нь  
мэргэжил, эсвэл шинжлэх ухаан  
мөн, бишийг тодруулах шалгуур  
дээр тавьж үзэх хэрэгтэй юм.  
Тийм шалгуур олон бий*



олон бий. Тухайлбал, Оросын эрдэмтэн Е.А.Климов мэргэжлийг таван том бүлэгт ангилсан байдаг. Тэрээр “хүн-хүн” гэсэн харилцааг илэрхийлдэг социономи буюу нийгмийн шинжтэй мэргэжил, “хүн-тэмдэгт” гэсэн харилцааг илэрхийлдэг сигнономи буюу тэмдэгтүүдийн шинжтэй мэргэжил (нябо, программ зохиогч гэх мэт), “хүн-уран сайхны дүр” гэсэн харилцааг илэрхийлж, уран сайхны дүрийн системтэй харилцдаг артономи шинжтэй мэргэжил (зохиолч, зураач гэх мэт), “хүн-байгаль” гэсэн харилцааг илэрхийлж, байгаль болоод хүрээлэн буй орчинтой харилцдаг хөдөө аж ахуйн шинжтэй мэргэжил (агрономич, ойн инженер гэх мэт), “хүн-машин” гэсэн харилцааг илэрхийлж, техниктэй харьцдаг техникийн шинжтэй мэргэжил (жолооч, механикч гэх мэт) хэмээн ангилсан байна.

Бүр 1915 онд Авраам Флекснерийн тодорхойлсон мэргэжлийн зургаан шинж чанарыг мэргэжил судлаач эрдэмтэд өнөөг хүртэл стандарт шалгуур болгон мөрдөж ирсэн юм. Тэрхүү зургаан шинж чанар нь нэгд, мэдлэгийн өргөн цар хүрээ бүхий адармаатай цогц бүрдэл; хоёрт, зөвхөн юу, яаж гэх төдийгүй, тэрчлэн яагаад гэдэгт хариулах онолын мэдлэг; гуравт, тодорхой практик зорилт; дөрөвт, зорилго хийгээд практикт шаардагдах боловсролын агуулгыг бусад мэргэжилтнүүдтэй зөвшилцөж тохиролцсон байх; тавд, практик ажлын нийтлэг шалгуур, эсвэл стандарт-элсэлтийн шаардлагыг хангасан байх; зургаад, энэрэнгүй, өөрийгөө дөвийлгөдөггүй, ашгийн сэдэлд үндэслэдэггүй байх зэрэг шинж чанарууд юм.

“Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн ёс зүй” сэтгүүлийн редактор, Алабамагийн Их Сургуулийн

профессор Жей Блак Флекснерийн тодорхойлолтыг шинжилж үзээд түүнд орчин үеийн шаардлагад тохирохгүй зүйл байгаа хэдий ч аливаа үйл ажиллагааны төрлийг мэргэжил мөн, биш гэж үзэхэд уг тодорхойлолт зайлшгүй хэрэгтэйг тэмдэглээд “Сэтгүүл зүй нь олон талаараа бүрэн боловсорсон мэргэжил болж чадаагүй нь илэрхий байна”<sup>3</sup> гэж дүгнэжээ. Тэрээр ингэж дүгнэхдээ Америкийн сэтгүүлчдэд нэгдмэл хувь шинж байхгүй, нэг зүйлийг адилхан эрхэмлэдэггүй, сэтгүүл зүйн үүргийн тухай нийтлэг тодорхойлолт байхгүй зэрэг шинжийг үндэс болгосон байна. Жей Блак мэргэжил гэдэг нь угтаа зүгээр л “мэргэших” гэсэн утгатай үг гээд Оксфордын англи хэлний хураангуй тольд дурьдсанаар “Ур чадвартай байх, эсвэл үлгэрлэн дуурайхуйц хэмжээнд мэргэшсэн ажил мэргэжил”, “Сургалтын тодорхой салбарт мэргэшсэн мэдлэгээ нийтийн үйл хэргийн төлөө ашигладаг ажил мэргэжил” гэж тодорхойлсныг иш татсан байна.

**Ж**ей Блак мэргэшинэ гэдэг бол тодорхой асуудлын талаар бусдын мэдэхгүй зүйл, түүнчлэн хурц сэргэлэн ухаан, зөн совингоороо мэдэх боломжгүй тийм мэдлэгийг эзэмших үйл явц гэж тодорхойлоод, мэргэшигчид чухам юуг мэдсэн байх, ямар хэмжээгээр мэдсэн байх ёстойг стандартын түвшинд тогтоож, тэр шалгуураар мэргэжил ба мэргэжилтнийг үнэлж дүгнэдэг байх ёстой гэсэн санааг дэвшүүлсэн юм. Энэ үүднээс авч үзвэл сэтгүүлчийг мэргэжил гэж үзэхэд учир дутагдалтай зүйл олон байгаа нь тодорхой юм. Юуны өмнө сэтгүүлчийн ажлыг авьяас мэдрэмжээрээ хийж болдгийг дурьдах хэрэгтэй. Аль ч улс оронд хэвлэл мэдээллийн хэрэгсэлд заавал сэтгүүлч мэргэжил-

тэй хүн ажиллах ёстой гэсэн хатуу журам байдаггүй. Нийгмийн үзэгдэл, үйл явдалд дүн шинжилгээ хийж чаддаг, бичиж найруулах чадвартай олон хүн сэтгүүлчээр ажилладаг. Нөгөө талаар сэтгүүлч болохоор суралцахад бусад мэргэжилд байдаг шиг хүнд бэрх, эсвэл аль нэг зүйлийг заавал мэдэхгүй бол тухайн ажлыг хийж чадахгүйд хүрэх хэмжээний нарийн ойлголт байдаггүй, өөрөөр хэлбэл хувь хүний мэдрэмж, үнэлэмжээр хийж болохуйц байдаг нь сэтгүүл зүйг мэргэжил гэж үзэхэд эргэлзээ төрүүлдэг. Хүний зүрхний үйл ажиллагаа, түүний аль нэг хэсэгт гарсан доголдлыг эмчээс, тэр тусмаа зүрхний эмчээс өөр хэн ч мэдэж оношилж чадахгүй. Тэд өөрийн тавьсан оношийг үлэмж нарийн ажиллагаатай техник хэрэгслээр давхар баталгаажуулж эцсийн оношийг тавьдаг. Гэтэл нийгэмд болж байгаа үйл явцыг сэтгүүлч, жирийн иргэд адил түвшинд үнэлж дүгнэдэг, тэр үзэл үнэлэлтээ бичиг зохиолд буулгахдаа сэтгүүлчээс дутахгүй ур чадвартай илэрхийлдэг хүн ч олон байдаг. Энэ нь сэтгүүлч бол авьяас мэдрэмжтэй хүн бүрийн хийж чадах ажил гэж үзэхэд хүргэдэг. Ингэж бодох бүрт “Хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн үед авьяас чадвар шаардсан мэргэжлүүд устана” гэж аль тэртээх XIX зууны дөчөөд онд К.Марксын хэлсэн үг санаанд ордог.

**Ө**ндөр хөгжилтэй орнуудад аливаа мэдлэг, үйл ажиллагааны хэлбэрүүд мэргэжлийн түвшинд очсон эсэхийг шалгаж үздэг шалгуур, стандартуудыг тогтоож, түүнийг мөрдөж хэвшүүлсэн байдаг. Жишээ нь, Америкийн Хөдөлмөрийн статистикийн товчоо гэхэд л боловсруулж тогтоосон боловсролын стандартууд, лицензжүүлэлт, гүйцэтгэлийн

стандартууд гэсэн гурван том бүлэгт багтах олон тооны шалгуураар мэргэжил мөн эсэхийг тогтоодог байна. Түүнээс гадна мэргэжил ямар шинжтэй байхыг тодорхойлж бичсэн “Америк дахь мэргэжлүүд” гэдэг номонд аливаа үйл ажиллагааны төрөл нь мэргэжил мөн эсэхийг тогтооход заавал анхаарах ёстой найман онцлог шинжийг жагсаасан байдаг. Үүнд:

-Аливаа мэргэжилтэн нь гадны хүнд “оюун ухааны судалгааг хязгаарлахуйц сэтгэл хөдлөл, уламжлалт байдал” зэрэг нөлөөлж болзошгүй асуудлыг бодитой болон лавлах байдлаар тунгаан бодож чаддаг байх (Энэ нь сэтгүүлчдэд хамаатай юу?),

-Аливаа мэргэжилтэн нь мэргэжлийн бус хүнд байхгүй тийм тодорхой экспертизтэй болтлоо мэргэшсэн байдаг тул түүнд итгэж болно гэж нийгэм хүлээн зөвшөөрдөг байх (Сэтгүүлчдэд ингэж итгэдэг үү?),

-Аливаа мэргэжилтэн нь бусадтайгаа нэгдмэл байж, мэргэжлийн гаднах хүмүүст нэгдмэл байдлаа харуулж ажиллахыг эрмэлздэг байх (Сэтгүүлчид ингэж чаддаг уу?),

-Аливаа мэргэжилтэн нь мэргэшлийн зэрэгтэй, баталгаатай, тогтвортой мэргэжилтэн болохоо гэрчлэх лицензтэй байх гэхчлэн мэргэжлийн наад захын стандартуудыг хангасан байх (Сэтгүүлчдэд ийм зиндаа, зэрэглэл бий юу?),

-Аливаа мэргэжилтэн нь зөвхөн гэрчилгээ, лицензтэй байхаас гадна мэргэжлийнхээ стандартыг хангаж чадахгүй тохиолдолд тухайн мэргэжлийн ажлыг хийх эрхгүй болдог байх (Сэтгүүлчийг мэргэжилдээ тэнцэхгүй байгааг тогтоох шалгуур, зөвхөн энэ шалтгаанаар халдаг тогтолцоо бий юу?),

-Аливаа мэргэжилтэн өөрийнх нь үйл ажиллагааг бусдынхтай тохирч байхаар зохицуулсан стандартад нийцэж байхын хамт илүү өндөр түвшний бүлэгт дэвшин ороход шаардагдах мэргэжлийн болон ёс зүйн дүрэмтэй байх (Сэтгүүлч мэргэжилд ийм дүрэм бий юу?),

-Аливаа мэргэжилтэн нь ёс зүйн дүрмээ хамгийн сайн баримталсан нэгэндээ мөнгөн болон хүндэтгэлийн урамшуулал үзүүлдэг тогтолцоотой болсон байх (Сэтгүүлчдийн хувьд ийм тогтолцоо бий юу?),

-Аливаа мэргэжилтэн нь хувьдаа олж авсан цогц мэдлэгээ мэргэжил нэгтнүүдтэйгээ хуваалцдаг байх ёстой (Сэтгүүлчдэд ийм хэвшил тогтсон уу?).

**Д**ээр дурьдсан шинжүүдэд харгалзуулан шинжилсний үр дүнд сэтгүүлч мэргэжил мөн эсэх тухай ярих нь илүү оновчтой болно. Мэдээж хэлбэр талаас нь харвал сэтгүүлчдийн нэлээд хэсгийг сургуулиар бэлтгэдэг, ажил олгогчид тэднийг үе үе аттестатчилдаг, сэтгүүлчид ёс зүйн дүрэмтэй байдаг, сэтгүүлчдийн байгууллага болон хэвлэл мэдээллийн газрууд ажилтнуудаа шагнаж урамшуулдаг зэрэг нэлээд үзүүлэлт мэргэжлийн шаардлагыг хангаж байгаа мэт байдаг. Гэтэл бас дээрх шаардлагуудыг хангахгүй үзүүлэлт ч олон байна. Жишээлбэл, сэтгүүлч мэргэжлийн стандарт байна уу, сэтгүүлчийг ямар шалгуураар сайн, муу гэж үнэлэх вэ, сэтгүүлчдэд мэргэшлийн зэрэг байдаг уу, сэтгүүлчид мэргэжлийнхээ үүргийг яг нэг хүн шиг жигд биелүүлж чаддаг уу, сэтгүүлчдэд олон нийт итгэл төгс байж чаддаг уу? гэх мэт олон асуулт хариултгүй үлдэж байгааг анзаарч болно.

Дээр дурдсан шаардлага, шалгууруудаар хэмжиж үзвэл сэтгүүл

зүй шинжлэх ухаан болоход дав даруй шийдвэрлэх асуудал олон байгаа нь харагдана. Сэтгүүл зүйн өмнө шинэ сэргэг, тэр тусмаа прагматик шинжтэй зорилтууд тулгарсаар байгаатай харьцуулбал тэдгээрийг онолын үүднээс тайлбарлах явдал хоцорсоор байгаа билээ. Зарим судлаачийн үздэгчлэн сэтгүүл зүй шинжлэх ухаан болохын хувьд өнөө хэр бүрэн цэгцэрч чадаагүй, бас онолын категориуд нь эмх цэгцгүй, нэг мөр болоогүй байна гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрдэг. Судалгааны категориуд нь хоорондоо зөрчилтэй, үндсэн ойлголтууд нь тогтворгүй, нэр томъёо нь маргаантай, судалгааны үндсэн ойлголтуудаа ч нэг мөр тогтоогүй зэрэг нь онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд саад учруулж байгаа билээ. Ойрын жишээ дурдахад “Сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэдэг ганц категорийг л гэхэд наад зах нь таван янзаар нэрлэж байна. Энэ нь сургалт, судалгаанд ойлгомжгүй байдал үүсгэж, улмаар сэтгүүл зүйн шинжлэх ухааныг хэт хялбарчлах сэтгэлгээнд хөтөлж байгаа хэрэг юм.

Оросын эрдэмтэн Е.П.Прохоров “Сэтгүүл зүй” гэдэг категорийг “Сэтгүүл зүй бол нийгмийн өвөрмөц институт”, “Сэтгүүл зүй бол үйл ажиллагааны төрлүүдийн систем”, “Сэтгүүл зүй бол мэргэжлүүдийн нийлбэр”, “Сэтгүүл зүй бол бүтээлүүдийн систем”, “Сэтгүүл зүй бол олон нийтийн мэдээллийг дамжуулдаг сувгийн нийлбэр” гэж тайлбарласан байна. Энэ нь логикийн хувьд учир дутагдалтай тодорхойлолт юм. Зүйрлээд бодоход “Дорж бол Дондог мөн”, “Дорж бол Дулмаа мөн” гэсэнтэй адилхан сонсогдож байна. Жишээ нь “Дорж бол бие хүн мөн” гэсэн бодомж байлаа гэхэд тэр хүн бичиж чаддаг, зурах авьяастай, сайхан илтгэдэг гэх мэт олон чадвартай байж

болно. Түүн шиг “Сэтгүүл зүй нийгмийн өвөрмөц институт” гэж үзвэл “үйл ажиллагааны төрөл”, “мэргэжлүүдийн нийлбэр”, “бүтээлүүдийн систем”, “мэдээлэл дамжуулдаг сувгийн нийлбэр” зэрэг нь тэрхүү нийгмийн институтийн өвөрмөц байдлыг илтгэж байгаа багтах харилцаатай ойлголт болох ёстой билээ. Судлаач С.Г.Корконосенко ч мөн л “Сэтгүүл зүй бол нийгмийн үйл ажиллагаа мөн”<sup>4</sup> гэсэн мөртөө Прохоровтой адил “нийгмийн үйл ажиллагаа”-тай зэрэгцэх харилцаатай олон бодомжуудыг нэрлэсэн байдаг. Сэтгүүл зүйн онолын категори хийгээд нэр томъёоны энэ мэт нэг мөр болоогүй ойлголтууд олон байна. Энэ нь сэтгүүл зүй шинжлэх ухаан болох боломжгүйд биш, өнгөрсөн хугацаанд түүний нийгмийн практик хэрэглээг эн тэргүүнд тавьж, онолын талыг орхигдуулсны үр дагавар билээ. Өөрөөр хэлбэл үйл ажиллагааны явцад хуримтлагдсан мэдлэгийг системчлэх, категориудыг оновчтой тодорхойлох шаардлагатайг харуулж байгаа юм.

“Сэтгүүлч” хэмээн дуудуулж, хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа хэнд ч гэсэн сэтгүүлч мэргэжил болоогүй, онолын нэгдсэн тогтолцоо төлөвшөөгүй гэдэг үг таатай сонсогдохгүй нь мэдээж. Тиймээс ч Америкийн сэтгүүл зүйн нэрт онолч Жон С.Меррилл тэргүүтэй хэсэг эрдэмтнийг эс тооцвол энэ салбарын судлаачдын олонх нь сэтгүүл зүйг мэргэжил мөн гэж нотлохыг эрмэлзэж иржээ. Тэдгээрийн үндэслэл, тодорхойлолтыг Амстердамын Их Сургуулийн багш Марк Дьюз 2005 онд нэгдмэл цогц ойлголт болгосон байна. Тэрээр сэтгүүл зүй мэргэжил байхын тулд “Олон нийтэд үйлчилдэг байх, мэдээлэл нь үнэн бодитой байх, автономит

байх, шуурхай байх, ёс зүйтэй байх”<sup>5</sup> гэсэн таван зарчмыг хангадаг байх ёстой гэж үзсэн юм. Сэтгүүл зүйг мэргэжлийн түвшинд гаргахад чиглэсэн энэ зарчим сэтгүүл зүйн хөгжлийн оргил үе гэж нэрлэгддэг ХХ зууны далаад оныг эс тооцвол бүрэн гүйцэд хэрэгжиж байсан үе үнэн хэрэгтээ үгүй юм. Хэвлэл мэдээллийн компаниуд томорч, олон нийтэд биш эзэд, хувьцаа эзэмшигчид, зар сурталчилгаа өгөгчиддөө илүү үнэнч ханддаг болсон үеэс сэтгүүл зүй хэрэглэгчдийн хувьд агаарт дүүжлээстэй мэт болсон билээ. Тэр орон зайг нөхөх шаардлагаар олон нийтийн сэтгүүл зүй гарч ирсэн. Түүний зорилго нь хэвлэл мэдээллийг олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлдэг болгох, үүргээ биелүүлэхэд нь чиглэсэн зориудын үйл ажиллагааг зохион байгуулах замаар сэтгүүлчдийг дадлагажуулах, энэхүү хөдөлгөөнд иргэд ба байгууллагуудыг татан оролцуулах явдал байв.

Уг хөдөлгөөний явц хийгээд мэдээллийн технологийн ололтын үр дүнд иргэд сэтгүүлч болох үйл явц буюу иргэний сэтгүүл зүй үүссэн билээ. Энэ нь иргэд мэдээллийг үйлдвэрлэгч болох сайн талтай ч сэтгүүл зүйн мэргэжлийн шинжийг бууруулсан, нэг талыг барьсан, ёс зүйгүй мэдээлэл элбэгшиж, улсын болон иргэний хувийн нууцыг эрээ цээргүй дэлгэх, оюуны хулгай нэмэгдэх, мэдээний сонголт муудах зэрэг сөрөг үр дагаврыг авчирсан юм. Энэ бүхэн нь эцсийн эцэст мөнөөх сэтгүүл зүйг мэргэжлийн болгох, онолжуулах үйлсэд саад тотгор болсныг судлаачид тэмдэглэх болсон билээ. Гэвч үүссэн цагаасаа эхлэн эерэг, сөрөг хоёр шинж чанарыг агуулсаар ирсэн сэтгүүл зүйн шинэ чиглэлийг нийгмийн ардчилалд шаардлагатай хараат бус, итгэл

төрүүлэхүйц, үнэн зөв, найдвартай, өргөн хүрээтэй, ач холбогдолтой мэдээлэл түгээдэг үйл ажиллагаа болгон хувиргаснаар сэтгүүл зүйн онолын хэвшмэл, царцанги байдлыг задалж, шинэ сэтгэлгээгээр хандах нэг шижим болох юм.

### Ишлэл

- <sup>1</sup> Фомичева И.Д. 1993. “Журналистика переходного периода: развитие практики и вызов науке”. Основные понятия теории журналистики. М., с.5.
- <sup>2</sup> Прохоров Е.П. 1993. “Предмет и структура науки о журналистике”. Основные понятия теории журналистики. М., с.26
- <sup>3</sup> Блэк Ж. 1987. Ворлд Медиа Репорт. Хавар., р.13-15
- <sup>4</sup> Корконосенко С.Г. 1995. Основы теории журналистики. СПб., с.3
- <sup>5</sup> Deuze M. 2005. What Is Journalism? Professional Identity and Ideology of Journalists Reconsidered. Journalism 6: 4, 442-464

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Норовсүрэн Л, Энхтуяа Х. 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ.,
2. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Гутгаар боть. УБ.,
3. Зулькафиль М. 1999. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.,
4. Зулькафиль М. 2017. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. УБ.,

5. Оюунгэрэл А. “Иргэний сэтгүүл зүй ба мэргэжлийн сэтгүүл зүй”. 2016. Сэтгүүлч, сэтгүүл зүйн бүтээл.
6. Прохоров Е.П. 1995. Введение в теорию журналистики. М.,
7. Горохов В.М. 1975. Закономерности публицистического творчества. М.,
8. Carrigan Don H. 1999. The Public Journalism Movement in America. London.
9. 1998. Don't Stop There! Five Adventures in Civic Journalism. Washington.
10. Esther Thorson. 1996. Civic Lessons. Madison.
11. Hewlet J. 1995. Writing for broadcast News. London-Toronto.
12. 1990. Handbook for Journalists of Central and Eastern Europe. World Press Freedom Committee. Rex Pand Fund.
13. Lunt P. 1993. Talk on television. London.
14. 1991. Manual for Young Journalists.
15. Stanley J. Baran, Dennis K. Davis. 2000. Mass Communication Theory. Wadsworth.
16. Merrill J. 1997. Journalism Ethics. New York.

### Summary

In this article, journalism as it has not been reached the level of science that has stable and recognized law and categories even though it became an influencing type of socio-political activities, were discussed by explaining it with my own thoughts and support of works of researchers of USA, Russia and other countries with high developed journalism.